**НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ**
**ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2010 оны 12 сарын 28 өдөр Дугаар 91 Улаанбаатар хот

АЖИЛТНУУДЫН АЖЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ,

ҮЗҮҮЛЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл ,Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.8 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ажилтнуудын улирал, хагас, бүтэн жилийн ажлыг дүгнэх журмыг нэгдүгээр хавсралтаар, дүгнэх үзүүлэлтүүдийг хоёрдугаар хавсралтаар, ажилтнуудын ажлыг дүгнэх үзүүлэлтүүдийг гуравдугаар хавсралтаар , албадын ажлыг дүгнэсэн үзүүлэлтүүдийг дөрөв, тав,зургаа, долоо, найм, ес дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг дэд захирал, албадын дарга нарт тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаалыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ Б.БАЙГАЛМАА

*Нийслэлийн Соёлын төв Өргөөний*
*ерөнхий захирлын 2010 оны 91 дүгээр*
*тушаалын 1–р хавсралт*

**АЖИЛТНУУДЫН УЛИРАЛ , ХАГАС , БҮТЭН ЖИЛИЙН**
**АЖИЛ ДҮГНЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, төлөвлөгөө зорилтоо биелүүлэх зорилгоор бий болгосон тухайн ажлын байран дээр ажиллаж буй ажилтны ажлын гүйцэтгэл, сахилга бат, хөдөлмөрийн бүтээмжийг дүгнэж, үнэлж урамшуулах болон хариуцлага тооцох үйл ажиллагааг зохицуулна.

1.2. “Ажил дүгнэх журам”-ыг нийт ажилтнууд нэгэн адил дагаж мөрдөнө.

**Хоёр. Ажил дүгнэх аргачлал**

2.1. Ажилтнуудын ажлын үр дүнг “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.8 –д заасны дагуу бүр албадын дарга нар дүгнэж жилд 2удаа захиргааны зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

2.2. Албадын дарга нарын ажлыг байгууллагын дарга дүгнэнэ.

2.3. Ажил дүгнэх үзүүлэлтийг байгууллагын хэмжээнд мөрдөх нийтлэг байдлаар гаргаж байгууллагын даргын тушаалаар батална.

2.4. Албадын дарга нар ажилтнуудын ажлын үр дүнг жилд 2удаа дүгнэх бөгөөд тус оны 6 сарын 20-н, 12 дугаар сарын 20-ны дотор дүгнэж байна.

2.5. Хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаа хожимдуулж үнэлгээгээ ирүүлсэн тохиолдолд уг албадын ажилтнуудын үнэлгээг захиргааны зөвлөл хэлэлцэхгүй бөгөөд удаа дараа хугацаа хожимдуулсан албадын дарга нарт хариуцлага хүлээлгэнэ.

2.6. Туршилтын хугацаагаар ажиллаж буй ажилтныг үндсэн үйл ажиллагааны урамшуулалд хамруулахгүй.

**Гурав. Ажил дүгнэсэн дүнг үндэслэн авах арга хэмжээ**

3.1. Ажилтанг жилийн үйл ажиллагааны үнэлгээ, дүнг үндэслэн дараах байдлаар шагнаж урамшуулна. Үүнд:

- Жилд хагас буюу бүтэн жилээр үр дүнгийн шагнал үр дүнгийн шагнал , улирлын цалинг 25-40 % хүртэлх хувиар цалингийн фондын хэмнэлтээс олгоно.
- Үнэ бүхий зүйлээр шагнах
- Үндсэн цалинг 25 % нэмэгдүүлэх
- Төрийн одон медаль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн засаг даргын шагнал, салбарын болон олон нийтийн байгууллагын шагналд тодорхойлох
- Байгууллагын зардлаар эх орны үзэсгэлэнт газраар аялуулах, гадаад орноор жуулчлуулах
- Гадаад, дотоод сургалтанд хамруулах , туршлага судлуулах

3.2 Ажилтан байгууллага, хамт олны нэрийг дуурсгах, хамт олны нэр хүнд, ашиг орлогод харшлах үйлдэл, эс үйлдлийг илрүүлж таслан зогсоосон, улс эх орондоо гавъяат үйл бүтээсэн, бусдыг үлгэрлэн манлайлж амжилтанд хүрсэн,

аюул ослын үед баатарлаг гавъяа байгуулсан бол тухайн ажилтны ажлын үзүүлэлтийг хамгийн өндрөөр үнэлж урамшуулна.

## Дөрөв. Журам хүчин төгөлдөр болох, өөрчлөлт оруулах

4.1. Энэхүү журамд шаардлагатай гэж үзвэл захиргааны зөвлөлийн санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

4.2. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

*Нийслэлийн Соёлын төв Өргөөний*
*ерөнхий захирлын 2010 оны 91 дүгээр*
*тушаалын 4–р хавсралт*

**ЗАХИРГААНЫ АЖ АХУЙН АЖИЛТАН БОЛОН**
**АЛБАДЫН ДАРГА НАРЫН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

| № | Ажлын үзүүлэлт | Үнэлгээний оноо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Ажлын төлөвлөлт, түүний биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 2 | Ажлын байрны тодорхойлолтын биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 3 | Дээд байгууллагын болон байгууллагын даргын тушаалын хэрэгжилт | 5, 3, 1, -3, -5 | |
| 4 | Хариутай албан бичиг, өргөдөл, гомдлын барагдуулалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 5 | Ажлын цагийн ашиглалтын байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 6 | Байгууллагын захиргаанаас зохиож буй олон нийтийн ажлын оролцоо | 5, 3, 1, -3, -5 | |
| 7 | Хариуцсан ажлын тайлан, мэдээг цагт нь үнэн зөв гаргаж өгсөн байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 8 | Хариуцсан ажлын чиглэлээр санаачилж хийсэн ажил, шинээр боловсруулсан баримт бичиг | 5, 3, 1, -3, -5 | |
| 9 | Хариуцсан ажлын чиглэлээр хийсэн үзлэг, шалгалт, илрүүлсэн зөрчлийг арилгуулсан байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 10 | Ажилтны ёс зүйн хэмжээг сахиж буй байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 11 | Хариуцан гүйцэтгэсэн ажлын чанар байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 12 | Бие дааж ажиллах чадвар | 5, 3, 1, -3, -5 | |
| | Ерөнхий дүн: | | |

Жич: Оноо тус бүрд ажил үүргийн гүйцэтгэлийн дараах хувь харгалзана. Үүнд:

5 оноо: - 90% - 100%
3 оноо: - 75% - 89%
1 оноо: - 60% - 74%
-3 оноо: - 51% - 61%
-5 оноо: - 50-иас дээш доош хувьтай.

Оноо тус бүрд дараах үнэлгээ харгалзана. Үүнд:

5 оноо: - Шаардлагаас үлэмж дээгүүр
4 оноо: - Шаардлагаас дээгүүр
3 оноо: - Шаардлага хангаж байгаа
-3 оноо: - Шаардлагыг бүрэн хангахгүй
-5 оноо: - Хангалтгүй

*Нийслэлийн Соёлын төв Өргөөний*
*ерөнхий захирлын 2010 оны 91 дүгээр*
*тушаалын 5–р хавсралт*

**ЖИЖҮҮР БОЛОН БАРИЛГЫН ЗАСВАРЧИН, МУЖААН НАРЫН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

| № | Ажлын үзүүлэлт | Үнэлгээний оноо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Ажлын байрны тодорхойлолтын биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 2 | Хариуцсан ээлжийн ажлын хөтлөлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 3 | Тогтоосон журмын дагуу ажлын байранд үзлэг, шалгалт хийсэн байдал, илрүүлсэн зөрчлийг илрүүлсэн зөрчлийг арилгуулсан байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 4 | Түрээслэгч нараас ирүүлсэн гомдол, саналын барагдуулалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 5 | Өгсөн үүрэг даалгаврын биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 6 | Ажлын цагны ашиглалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 7 | Байгууллагаас зохион байгуулж буй ажлын оролцоо | 5, 3, 1, -3, -5 | |
| | Ерөнхий дүн: | | |

Жич: Оноо тус бүрд ажил үүргийн гүйцэтгэлийн дараах хувь харгалзана. Үүнд:

5 оноо: - 90% - 100%
3 оноо: - 75% - 89%
1 оноо: - 60% - 74%
-3 оноо: - 51% - 61%
-5 оноо: - 50-иас дээш доош хувьтай.

Оноо тус бүрд дараах үнэлгээ харгалзана. Үүнд:

5 оноо: - Шаардлагаас үлэмж дээгүүр
4 оноо: - Шаардлагаас дээгүүр
3 оноо: - Шаардлага хангаж байгаа
-3 оноо: - Шаардлагыг бүрэн хангахгүй
-5 оноо: - Хангалтгүй

*Нийслэлийн Соёлын төв Өргөөний*
*ерөнхий захирлын 2010 оны 91 дүгээр*
*тушаалын 6–р хавсралт*

## ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

| № | Ажлын үзүүлэлт | Үнэлгээний оноо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Ажлын цаг ашиглалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 2 | Ажлын байрны цэвэрлэгээ | 5, 3, 1, -3, -5 | |
| 3 | Түрээслэгч буюу хэрэглэгчдээс ирсэн санал гомдлын барагдуулалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 4 | Техник хэрэгслийн бүрэн бүтэн, хэвийн ажиллагаанд үзлэг шалгалтыг тогтмол хийсэн байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 5 | Техникийн засвар үйлчилгээг хийсэн байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 6 | Захиргаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 7 | Техник аюулгүй ажиллагааны биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 8 | Цаг үеийн ажлын оролцоо /цас, мөсний цэвэрлэгээ, тохижилтын ажил/ | 5, 3, 1, -3, -5 | |
| | Ерөнхий дүн: | | |

Жич: Оноо тус бүрд ажил үүргийн гүйцэтгэлийн дараах хувь харгалзана. Үүнд:

5 оноо: - 90% - 100%
3 оноо: - 75% - 89%
1 оноо: - 60% - 74%
-3 оноо: - 51% - 61%
-5 оноо: - 50-иас дээш доош хувьтай.

Оноо тус бүрд дараах үнэлгээ харгалзана. Үүнд:

5 оноо: - Шаардлагаас үлэмж дээгүүр
4 оноо: - Шаардлагаас дээгүүр
3 оноо: - Шаардлага хангаж байгаа
-3 оноо: - Шаардлагыг бүрэн хангахгүй
-5 оноо: - Хангалтгүй

*Нийслэлийн Соёлын төв Өргөөний*
*ерөнхий захирлын 2010 оны 91 дүгээр*
*тушаалын 7–р хавсралт*

**МАРКЕТИНГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН**
**АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

| № | Ажлын үзүүлэлт | Үнэлгээний оноо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Ажлын цаг ашиглалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 2 | Ажлын байрны цэвэрлэгээ | 5, 3, 1, -3, -5 | |
| 3 | Үйлчлүүлэгчдээс ирсэн санал гомдол | 5, 3, 1, -3, -5 | |
| 4 | Хувцаслалт / Үс засалт, энгэрийн зүүлт, хувцас / | 5, 3, 1, -3, -5 | |
| 5 | Захиргаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 6 | Хувцасны өлгүүрийн үйлчилгээ | 5, 3, 1, -3, -5 | |
| 7 | Цаг үеийн ажлын оролцоо /цас, мөсний цэвэрлэгээ, тохижилтын ажил/ | 5, 3, 1, -3, -5 | |
| | Ерөнхий дүн: | | |

Жич: Оноо тус бүрд ажил үүргийн гүйцэтгэлийн дараах хувь харгалзана. Үүнд:

5 оноо: - 90% - 100%
3 оноо: - 75% - 89%
1 оноо: - 60% - 74%
-3 оноо: - 51% - 61%
-5 оноо: - 50-иас доош хувьтай.

Оноо тус бүрд дараах үнэлгээ харгалзана. Үүнд:

5 оноо: - Шаардлагаас үлэмж дээгүүр
4 оноо: - Шаардлагаас дээгүүр
3 оноо: - Шаардлага хангаж байгаа
-3 оноо: - Шаардлагыг бүрэн хангахгүй
-5 оноо: - Хангалтгүй

*Нийслэлийн Соёлын төв Өргөөний*
*ерөнхий захирлын 2010 оны 91 дүгээр*
*тушаалын 8–р хавсралт*

# УРАН БҮТЭЭЛ, ТЕХНИКИЙН АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

| № | Ажлын үзүүлэлт | Үнэлгээний оноо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Ажлын цаг ашиглалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 2 | Ажлын байрны цэвэрлэгээ | 5, 3, 1, -3, -5 | |
| 3 | Үйлчлүүлэгчдээс /тоглолт, арга хэмжээ зохион байгуулагч/ ирсэн санал гомдлын барагдуулалт | 5, 3, 1, -3, -5 | |
| 4 | Техник хэрэгслийн бүрэн бүтэн, хэвийн ажиллагаанд үзлэг шалгалтыг тогтмол хийсэн байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 5 | Техникийн засвар үйлчилгээг хийсэн байдал | 5, 3, 1, -3, -5 | |
| 6 | Захиргаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 7 | Техник аюулгүй ажиллагаганааны биелэлт | 5, 3, 1, -3, -5 | |
| 8 | Цаг үеийн ажлын оролцоо /цас, мөсний цэвэрлэгээ, тохижилтын ажил/ | 5, 3, 1, -3, -5 | |
| | Ерөнхий дүн: | | |

Жич: Оноо тус бүрд ажил үүргийн гүйцэтгэлийн дараах хувь харгалзана. Үүнд:

5 оноо: - 90% - 100%
3 оноо: - 75% - 89%
1 оноо: - 60% - 74%
-3 оноо: - 51% - 61%
-5 оноо: - 50-иас дээш доош хувьтай.

Оноо тус бүрд дараах үнэлгээ харгалзана. Үүнд:

5 оноо: - Шаардлагаас үлэмж дээгүүр
4 оноо: - Шаардлагаас дээгүүр
3 оноо: - Шаардлага хангаж байгаа
-3 оноо: - Шаардлагыг бүрэн хангахгүй
-5 оноо: - Хангалтгүй